



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 72


Улаанбаатар хот

“Аккаунт траст аудит” ХХК-д даатгалын
байгууллагад аудит хийх эрх олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 7 дугаар хавсралтын 2.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Аккаунт траст аудит” ХХК-д даатгалын байгууллагад аудит хийх эрх олгосугай.
2. Аудитын үйл ажиллагааны стандарт, хууль тогтоомжийн дагуу чанарын хяналтыг хэрэгжүүлж ажиллах, чанарын хяналт шалгалтын үнэлгээг тухай бүр Хороонд ирүүлэх, холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Аккаунт траст аудит” ХХК /П.Наранцэцэг/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН